

МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮРТГЭЛИЙН ДЭВТЭР ХӨТЛӨХ, ТАЙЛАН, МЭДЭЭ ИРҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн болон барьцаа хөрөнгийн бүртгэлийг хөтлөх, тайлан мэдээ ирүүлэх, холбогдох эрх бүхий байгууллагатай мэдээлэл солилцохтой холбогдох харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь өөрийн үйл ажиллагааны эрсдэлийг удирдах, хяналт тавих зорилгоор Хорооноос тогтоосон мэдээ тайлангаас гадна бусад хэм хэмжээг холбогдох хууль, журамд нийцүүлэн боловсруулж, дотооддоо мөрдүүлж болно.

ХОЁР. БҮРТГЭЛИЙН ДЭВТЭР ХӨТЛӨХ

- 2.1. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь олгосон зээлийн болон барьцаа хөрөнгийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан энэхүү журмын нэгдүгээр хавсралтаар баталсан бүртгэлийн дэвтрийг цахим системд холбогдсон программ хангамж ашиглан өдөр тутмын үйл ажиллагаандаа хөтөлнө.
- 2.2. Бүртгэлийн дэвтэрт заасан барьцаа хөрөнгийн зургийг бүтэн, тод, гаргацтай тухайн барьцаа хөрөнгийг илэрхийлэх загвар, марк, дугаар, жин, онцлог шинжийг харуулсан байдлаар авч цахим системд оруулна.
- 2.3. Мөнгөн зээлийн үйлчилгээ эрхлэх этгээдүүдийн Бүртгэлийн дэвтрийн нэгдсэн мэдээллийн сан Санхүүгийн зохицуулах хороонд байршина.

ГУРАВ. МЭДЭЭ, ТАЙЛАН

- 3.1. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд баталсан загвар маягтын дагуу дараах тайланг хагас, бүтэн жилээр өссөн дүнгээр гаргаж, дараа сарын 20-ны өдрийн дотор харьяалах бүртгэх байгууллагад цахимаар ирүүлнэ:
 - 3.1.1. Зээлийн нэгдсэн тайлан /Хавсралт 2/
 - 3.1.2. Хураангуй тайлан /Хавсралт 3/
 - 3.1.3. Үүрэг гүйцэтгэсэн зээлийн мэдээ /Хавсралт 4/
 - 3.1.4. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон шаардлагатай бусад мэдээлэл.
- 3.2. Мэдээ тайлангийн ирц, бүрэн бүтэн байдалд Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 23.4-т заасны дагуу харьяалах бүртгэх байгууллага нь хяналт тавина.
- 3.3. Харьяалах бүртгэх байгууллагын бүртгэл хариуцсан нэгж нь хагас, бүтэн жилийн тайлан мэдээг хянан дараа сарын 30-ны өдрийн дотор баталгаажуулсан байна.

“Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн
тайлан, мэдээ ирүүлэх журам”-ын хавсралт 2

ЗЭЭЛИЙН НЭГДСЭН ТАЙЛАН

0000/СС/ӨӨ

/төгрөгөөр/

№	Барьцааны ангилал	Нийт зээлийн эхний үлдэгдэл /0000.01.01/		Нийт олгосон зээл			Нийт төлөгдсөн зээл		Нийт зээлийн эцсийн үлдэгдэл			
		Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Хүү /сараар/	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Хүү /сараар/	
		Нийт	-	-	-	-	#DIV/0!	-	-	-	-	#DIV/0!
1	Тээврийн хэрэгсэл									-		
2	Цахилгаан хэрэгсэл									-		
3	Тавилга эд хогшил									-		
4	Үнэт эдлэл									-		
5	Орлого									-		
6	Эзэмших эрх									-		
7	Мал									-		
8	Тоног төхөөрөмж									-		
9	Бараа материал, хувцас хэрэглэл											
10	Бусад											

*"Бусад" ангилалд энэхүү нэгдсэн тайлангийн "барьцааны ангилал" хэсэгт дурдагдаагүй барьцаа хөрөнгүүд хамаарна.
*тайлант хугацаанд олгосон болон төлөгдсөн нийт зээлийг хамааруулна.

“Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн
тайлан, мэдээ ирүүлэх журам”-ын хавсралт 3

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

0000/СС/ӨӨ

/төгрөгөөр/

ХӨРӨНГӨ		ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	
1.ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		1. ӨР ТӨЛБӨР	
1.1	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1.1	ЗЭЭЛ
	Бэлэн мөнгө		Банкнаас авсан зээл
	Харилцахад байршуулсан		Зохицуулалттай хуулийн этгээдээс авсан зээл
	Хадгаламжид байршуулсан		Зохицуулалттай хувь хүнээс авсан зээл
1.2	НИЙТ ЗЭЭЛ	1.2	ГАРГАСАН ӨРИЙН БИЧИГ
	Хугацаандаа байгаа (20 хүртэлх хоног хугацаа хэтэрсэн)	1.3	БУСАД ӨР ТӨЛБӨР
	Хугацаа хэтэрсэн (21-ээс дээш хоног хугацаа хэтэрсэн)	2. ЭЗДИЙН ӨМЧ	
1.3	ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГӨ	2.1	ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ
1.4	БУСАД ХӨРӨНГӨ	2.2	ХУРИМТЛАГДСАН АШИГ/АЛДАГДАЛ
2. ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ			Тухайн үеийн ашиг/алдагдал
2.1	ҮНДСЭН (БИЕТ) БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)		Хуримтлагдсан ашиг/алдагдал
	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө		
	(Хуримтлагдсан элэгдэл)		
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	
ЗАРДАЛ		ОРЛОГО	
	Цалингийн зардал		Зээлийн хүүгийн орлого
	Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн зардал		Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого
	Үйл ажиллагааны зардал		Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого
	Түрээсийн зардал		Нэмэгдүүлсэн хүүгийн орлого
	Бусад зардал		Харилцах, хадгаламжийн хүүгийн орлого
	Орлогын албан татварын зардал		Бусад хүүгийн орлого
			Бусад орлого
		ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО	
			Зээлийн ҮНДСЭН төлбөрт хүлээн авсан мөнгөн дүн
			Зээлийн ХҮҮГИЙН төлбөрт хүлээн авсан мөнгөн дүн
			Барьцаа хөрөнгө борлуулснаас хүлээн авсан мөнгөн дүн

“Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн
тайлан, мэдээ ирүүлэх журам”-ын хавсралт 4

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭСЭН ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

0000/СС/ӨӨ

/төгрөгөөр/

№	Зээлдэгчийн				Зээл					Үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар нэхэмжилсэн дүн	Үүрэг гүйцэтгэсэн			
	Овог, нэр	Регистрийн дугаар	Харьяалал /хот, аймаг/	Харьяалал /сум, дүүрэг/	Олгосон огноо	Олгосон дүн	Төлөгдсөн дүн	Үлдэгдэл дүн	Хугацаа хэтэрсэн хоног		Огноо	Дуудлага худалдаагаар зарагдсан дүн	Төлөгд- сөн дүн	Эцсийн үлдэгдэл
	-	Нийт дүн			xxx	-	-	-	xxx		-	xxx	-	
1														
2														

*хугацаа хэтэрсэн хоногийг гэрээнд заасан төлж дуусах огнооноос хойш тоолно.

